



НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 04 сарын 04 өдөр

Дугаар А/НО

Улаанбаатар хот

Хан-Уул дүүргийн Засаг даргын
Тамгын газрын балансад бүртгэлтэй
барилга акталж, данс бүртгэлээс хасах тухай

Монгол Улсын Засаг, захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2024 оны 14 дүгээр тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/301 дүгээр захирамж, "Нийслэлийн Өмчийн харилцааны газрын дүрэм"-ийн 7.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар хуучин барилгыг буулгаж цэцэрлэгт хүрээлэн авто зогсоол барих болсонтой холбогдуулан Хотын стандарт, хяналтын газрын Барилгын техникийн хяналтын улсын байцаагчийн 2023 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 02-13-01/033/234 дугаар дүгнэлтээр ашиглалтын шаардлага хангахгүй болох нь тогтоогдсон, Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газрын балансад бүртгэлтэй нийт 827,060,531.80 (найман зуун хорин долоон сая жаран мянга таван зуун гучин нэгэн төгрөг наян мөнгө) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хавсралтад заасан барилга, байгууламжийг акталж, данс бүртгэлээсээ хасахыг Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газар (С.Энхбаяр)-т зөвшөөрсүгэй.

2. Данснаас хасагдаж буй барилга байгууламжийг буулгахад гарах хоёрдогч түүхий эдийн зориулалтаар ашиглаж болох материалыг худалдан борлуулж 4,842,000.00 (дөрвөн сая найман зуун дөчин хоёр мянга) төгрөгийг Нийслэлийн Өмчийн харилцааны газрын Нийслэлийн төрийн сангийн 100200051024 тоот дансанд төвлөрүүлэхийг Хан-Уул дүүргийн Засаг даргын тамгын газар (С.Энхбаяр)-т, Захиргаа, төлөвлөлт, санхүүгийн хэлтэс (М.Мөнхбаяр)-т тус тус үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн хяналт, ашиглалт, дотоод аудитын хэлтэс (Г.Тэмүүжин)-т үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



В.ОЮУМАА

1150500184

Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын
 2024 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн
 А.М. дугаар тушаалын хавсралт



Барилга байгууламж данснаас хасах тухай

№	Барилга байгууламжийн нэр	Ашиглалт ад орсон он	Байршил	Бүртгэлийн үнэ	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэгдэл өртөг /2023.12.31/	Акталж, данснаас хасах үндэслэл
1	Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газрын хуучин барилга	1970	Хан-Уул дүүрэг 20 дугаар хороо	827,060,531.80	179,795,767.80	647,264,764.00	Хотын стандарт, хяналтын газрын Барилгын техникийн хяналтын улсын байцаагчийн 2023 оны 02-13-01/033/234 дугаар дүгнэлт
НИЙТ ДҮН				827,060,531.80	179,795,767.80	647,264,764.00	